

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2017-2021/

д/д	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хугацаа	Шаардагдах төсөв
1. “Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэсэн Зорилт 1-ийн хүрээнд					
1.1.	Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал /шалтгаан, үйлдэгдэж буй арга зам, сувгууд, хор уршиг, нэгдсэн бүртгэл/-ын судалгааг хийнэ:	Энэ чиглэлээр судалгааны ажил хийх байгууллага, эрдэмтэн судлаачдын багт тавигдах шаардлагыг тодорхойлно;	ХЗДХЯ Дэд зөвлөл	2017 он	10,0
		Судалгаа хийх байгууллага, эрдэмтэн судлаачдын багийг сонгон шалгаруулна;	ХЗДХЯ Дэд зөвлөл	2017 он	
		Судалгааны үр дүнг үндэслэн цаашид авах арга хэмжээний талаар санал, зөвлөмж гаргана;	ХЗДХЯ Дэд зөвлөл	2017 он	
		Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал (шалтгаан, гаралт, нөхцөл байдал, нэгдсэн тоо бүртгэл, үйлдэгдэж байгаа арга зам, хор уршиг гэх мэт) талаар судалгаа хийж Засгийн газарт танилцуулна.	ХЗДХЯ ХСИС ЦЕГ	2017 он	
1.2.	Энэ төрлийн гэмт хэргийн мэдээллийн санг үүсгэнэ:	Мэдээллийг хүлээн авах бүхий сувгийг бий болгоно;	ХЗДХЯ Дэд зөвлөл	2017-2018 он	20,0
		Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллийн сан /Хүний наймаанд өртөх эрсдэл өндөртэй бүлгүүд, энэ төрлийн гэмт хэрэгт сэжиглэгдэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэрч, хохирогчийн мэдээлэл, байршил, хаягийн зураглал/-г үүсгэн, хүлээн авах, тогтмол баяжуулах тогтолцоог бий болгон, үйл ажиллагаа бүрэн явуулах техник, тоног төхөөрөмжөөр хангана.	ХЗДХЯ Дэд зөвлөл Цагдаагийн байгууллага	2017 он	
1.3.	Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх сургалт, сурталчилгаа явуулах бэлтгэл ажлыг хангана:	Судалгааны санал дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн сургалт, сурталчилгааны агуулга, хөтөлбөрийг боловсруулж, батлуулна;	ХЗДХЯ Дэд зөвлөл	2017 он	-
		Тухайн хэрэгцээт сургалт, сурталчилгааны материал, контентыг боловсруулах, сургалт явуулах багуудад тавигдах шаардлагыг батлах, сонгон шалгаруулалт зарлах ажлыг зохион байгуулна;	ХЗДХЯ Дэд зөвлөл	2017 он	
		Санал, дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн сургалт, сурталчилгааны материал боловсруулах, сургалт зохион байгуулах баг болон сурталчилгааны чиглэлээр ажиллах хэвлэл, мэдээллийн байгууллагыг	ХЗДХЯ Дэд зөвлөл	2017 он	

		шалгаруулна;			
		Сургалт, сурталчилгааны болон хэвлэл, мэдээллийн багтай хамтран ажиллах гэрээ байгуулж, биелэлт хяналт тавьж, тэднийг мэргэжлийн удирдлагаар хангана.	ХЗДХЯ Дэд зөвлөл	2017 он	
1.4.	Хүн худалдаалах гэмт хэргийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд сургалт явуулна:	Сургалт, сурталчилгааны болон хэвлэл, мэдээллийн баг нь дараах бүлгүүдэд теле, ганцаарчилсан, танхим болон сургалтын бүх хэлбэрээр явуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулна:  -хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх магадлалтай зорилтот бүлэг /орон гэргүй иргэд, саун массаж, цэнгээний газарт ажиллагсад, биеэ үнэлэгч, ядуу амьдралтай гэр бүл, сургууль завсардсан хүүхдүүд, бага цалинтай буюу ажил идэвхтэй хайж байгаа иргэд, гадаадад зорчих баримт бичиг, тодорхойлолт хүссэн иргэдэд/;  -Бар, ресторан, массаж, гоо сайхны газар, бүжгийн клуб, зочид буудал, аялал жуулчлал, зуучлалын үйлчилгээ зэрэг чиглэлээр бизнес эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжийн эзэд, менежерүүдэд.  Хүн худалдаалах гэмт хэрэг, түүний хор уршгийн талаар сургалтын материал /ном, гарын авлага, онлайнаар унших болон сонсох хичээл, онлайн зөвлөмж гэх мэт/-ыг бэлтгэх, хэвлэх, тараах ажлыг дунд болон ахлах ангийн сургалтын хөтөлбөрт тухайн сургуулийн нийгмийн ажилтнаар дамжуулан улиралд 1 удаа сургалт зохион байгуулна;	ХЗДХЯ Дэд зөвлөл, БСШУСЯ, ГХЯ, ХТҮГ, ХЭҮК, ЗБГХТГ, Бүх шатны ЗД нар, ОӨУБЕГ, МХЕГ, ТББ-ууд	2017-2020	50,0
		Зорилтот бүлгүүдэд хүн худалдаалах гэмт хэргийн хор уршиг, энэ төрлийн гэмт хэргийн сэжиг илэрвэл хаана хандах, ямар арга хэмжээ авах зэрэг урьдчилан сэргийлэх шаардлагатай сургалтыг явуулна;	ХЗДХЯ Дэд зөвлөл БСШУСЯ		
		Сургалтын онлайн цахим хуудас /вэб/ бүтээх, сошиал медиа /facebook, twitter гэх мэт/ нээх, тогтмол ажиллагаатай болгоно.	ХЗДХЯ Дэд зөвлөл БСШУСЯ		
1.5	Хууль, хяналтын байгууллагын болон бусад байгууллагын ажилтнуудад сургалт	Цагдаагийн байгууллага, эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн ажилтан, прокурор, шүүгчид, хамгаалах байрны ажилтнууд, өмгөөлөгч, сэтгэлзүйч нарт сургалт явуулна;	ХЗДХЯ, ШЕЗ, УЕПГ, ХНХЯ, ЭМЯ, Хуульчдын	2017-2018 он	20,0

	явуулна:	Орон нутгийн хууль, хяналтын байгууллагын болон хилийн бүх боомтуудын албан хаагчдад сургалт зохион байгуулна;	холбоо, ТББ	2018-2020	Төрийн бус байгууллагуудын дэмжлэгээр
		Хэвлэл мэдээллийн, хүүхдийн асрах, сургуулийн нийгмийн ажилтнууд, дипломат албаны ажилтан, аялал жуулчлалын бизнес эрхлэгчид болон төрийн зохих албан тушаалтнуудыг сургалтад хамруулна;	ХЗДХЯ, ХТҮГ, БСШУСЯ, Сэтгүүлчдийн холбоо	2017-2018 он	
		Гадаад улсад суух дипломат төлөөлөгчдийн газрын ажилтнуудад томилогдохын өмнө хууль, хүний эрхийн чиглэлээр сургалт явуулна;	ХЗДХЯ, ГХЯ	2017-2021 он	
		Хүүхэд залууст энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хэлэлцүүлэг, яриа тогтмол хийх, сургагч багш, нийгмийн ажилтныг тогтмол сургаж, дадлагажуулна.	БСШУСЯ, Цагдаагийн байгууллага, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ	2017-2021	10,0
1.6.	Хүн худалдаалах гэмт хэргийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сурталчилгааг үр дүнтэй зохион байгуулна:	Сурталчилгаа, хэвлэл, мэдээллийн баг нь олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сурталчилгааны контент /хүүхдэд зориулсан анимац, нийтлэл, мэдээлэл, богино хэмжээний баримтат кино, шторк, нэвтрүүлэг, уран сайхны кино, зураг, сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудас гэх мэт/-ыг бүтээнэ;	ХЗДХЯ Дэд зөвлөл БСШУСЯ	2017-2021	100,0
		Контентийг төв орон нутгийн телевиз, радио, сонин, сэтгүүл зэрэг мэдээллийн хэрэгслээр болон интернетийн орчинд, сошиал медиагаар тогтмол түгээнэ;	ХЗДХЯ Дэд зөвлөл, Шалгарсан баг болон хэвлэл, мэдээллийн баг МҮОНРТ ТББ		
		Нисэх буудал болон олон улсын чанартай хилийн боомтууд, төмөр зам, автобусны буудал, томоохон худалдаа үйлчилгээний газар зэрэг олон нийтийн газарт бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн аюул, занал хийгээд хүн худалдаалах гэмт хэргийн талаарх сэрэмжлүүлэг, мэдээлэл түгээнэ.	ХЗДХЯ Дэд зөвлөл, ГХЯ, Цагдаагийн байгууллага		
		Хүн худалдаалахтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хор уршигтай холбоотой радио, телевизийн нэвтрүүлэг болон сонин, сэтгүүлийн нийтлэлийн уралдаан зарлаж шалгаруулна.	ХЗДХЯ Дэд зөвлөл, ТББ	2018, 2020 он	20,0

1.7.	Хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна:	Хүүхдэд зориулсан сурталчилгааг телевизийн хүүхдийн нэвтрүүлэг, радио, хүүхдэд зориулсан сонин, сэтгүүл, интернетийн орчинд түгээхээс гадна сургууль, кино театр зэрэг хүүхэд залуус олноор үйлчлүүлдэг үйлчилгээний байгууллагын зааланд санамж, сэрэмжлүүлэг байршуулж, сурталчилна;	ХЗДХЯ, БСШУСЯ	2017-2020	60,0
		Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хүн худалдаалах гэмт хэргийн хор уршиг, энэ төрлийн гэмт хэргийн сэжиг илэрвэл хаана хандах, ямар арга хэмжээ авах зэрэг урьдчилан сэргийлэх шаардлагатай сургалт, сурталчилгааг тогтмол явуулна;	ХЗДХЯ, БСШУСЯ, ХТҮГ		
		Оюутан, сурагчдын сургалтын програмд энэ төрлийн гэмт хэрийн тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хичээлийг сургалтын хөтөлбөрт тусгуулах арга хэмжээ авч, сургалтын хөтөлбөр, ном, сургалтын гарын авлага бэлтгэнэ;	ХЗДХЯ, БСШУСЯ		
		Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг сайн дурын хөдөлгөөн өрнүүлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор нөлөө, аюулын талаарх эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, илтгэл, эссэ бичлэгийн уралдаан зарлах, хүн худалдаалах гэмт хэргээс ангид байх талаар уриалга гаргах зэргээр олон төрлийн үйл ажиллагаанд оюутан залуусыг идэвхитэй оролцуулах үйл ажиллагааг дэмжин явуулна;	ХЗДХЯ, ТББ, Их дээд сургуулиуд		
		Ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн вэб сайт, мэдээллийн самбарт хүн худалдаалах гэмт хэргийн аюулын талаар зурагт хуудас, богино хэмжээний шторк, сэрэмжлүүлэх мэдээллийг тогтмол байршуулна;	ХЗДХЯ Дэд зөвлөл, БСШУСЯ		
		Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэдтэй ажилладаг сургуулийн багш, асрамжийн газрын ажилтнууд, хүүхдэд зориулсан сургалт дамжаа хичээллүүлдэг сургалтын төвүүд, ТББ-уудын ажилтнуудыг энэ төрлийн гэмт ойлголт, урьдчилан сэргийлэх талаар сургалтад хамруулна.	ХЗДХЯ Дэд зөвлөл, БСШУСЯ		
1.8.	Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдэд тогтмол мониторинг хийж,	Сургалтын үйл ажиллагааг хянан, үр дүнг сайжруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулна; Сурталчилгааны үр нөлөөг зохих индикатор, шалгуур үзүүлэлтийг үндэслэн хэмжих, сурталчилгааны үр нөлөөг тогтмол дээшлүүлэх арга хэмжээ авна;	ХЗДХЯ Дэд зөвлөл	2017-2021 он	

	үнэлгээ өгнө:	Сургалт, сурталчилгаа, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд жил бүр мониторинг хийнэ.	ХЗДХЯ Дэд зөвлөл	2017-2021 он	
1.9.	Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулна:	Бүжгийн клуб, зочид буудал, саун, массаж болон гоо сайхны газар, зоогийн газар, амралтын газар, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж зэргийн өмчлөгч болон менежерүүдийн үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомж, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийнэ; Саун массаж, зочид буудлын үйл ажиллагааны стандарт, хяналтыг сайжруулах, садар самуун сурталчлах, бие үнэлэхийг зохион байгуулсан этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулна.	ХЗДХЯ Дэд зөвлөл	2017-2021 он	
2.	“Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн болон өртөх магадлалтай иргэдийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх” Зорилт 2-ын хүрээнд:				
2.1.	Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчийг хамгаалах байрыг байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулна:	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг байрлуулах хамгаалах байрыг бий болгох, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх, холбогдох зардлыг улсын төсөвт суулгах арга хэмжээ авна; Хамгаалах байрны стандартад нийцүүлэн хамгаалах байрны дүрэм журмыг шинэчлэн боловсруулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.	ХЗДХЯ дэд зөвлөл, ХНХЯ	2017-2021 он	
2.2.	Хохирогчдод үзүүлэх үйлчилгээг ажлыг тогтмолжуулна:	Хууль зүйн туслалцаа үзүүлнэ; Эрүүл мэндийн болон сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээ үзүүлнэ; Гадаадад байгаа хохирогч болсон Монгол улсын иргэдэд туслах, эх оронд нь буцаан авчрах ажлыг зохион байгуулна; Хохирогчийг тээвэрлэх тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр хангана;	ХЗДХЯ дэд зөвлөл Хуульчдын холбоо ХЗДХЯ дэд зөвлөл, ЭМЯ ГХЯ, Гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар ХЗДХЯ Дэд зөвлөл Цагдаагийн байгууллага	2017-2021 он	150,0

		Ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулна;	ХНХЯ		
		Энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчдыг ажлын байраар хангасан аж ахуйн нэгжийг төрөөс дэмжиж, урамшуулах бодлого боловсруулна;	ХЗДХЯ дэд зөвлөл, ХНХЯ	2017 он	
		Эрсдэлд буй этгээдийн нөхцөл байдалд үнэлгээ өгөх, тэднийг нийгмийн хамгааллын тусгай хөтөлбөрт хамруулна;	ХНХЯ	2017-2021 он	
		Монгол Улсын нутаг дэвсгэр дээр энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон гадаадын иргэдэд туслалцаа үзүүлэх, дипломат албаны шугамаар эх оронд нь буцаах үйлчилгээ үзүүлнэ.	ГХЯ, ГИХГ, ЗБГХТГ	2017-2021 он	
2.3.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийг хамгаалах арга хэмжээ авна:	Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж байгаа болон тэр дундаа хөдөлмөрийн мөлжлөг/мал маллах, морь унах, айлын хүүхэд харах, гуйлга гуйх гэх мэт/-т өртөж байгаа хүүхдийн талаарх судалгааг гаргана;	ХЗДХЯ, ХНХЯ, ЦЕГ, ХТҮГ	2017 он	20,0
		Хууль тогтоомжид энэ төрлийн гэмт хэрэгт хүүхдийг татан оруулахгүй байх, хүүхдийг хамгаалах талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно;	ХЗДХЯ, ХНХЯ, ХТҮГ	2017-2021 он	
		Нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөрүүдийг боловсруулахад энэ төрлийн гэмт хэрэгт өртөх болон өртсөн хүүхдийг хамгаалахад чиглэгдсэн шалгуур үзүүлэлтийг тусгана;	ХНХЯ, ХТҮГ	2017 он	
		Энэ төрлийн гэмт хэрэгт хохирогч болсон хүүхдүүдийг хамгаалалтад авч шаардлагатай тохиолдолд асрамж халамжийн төвд хүргэх, тэднийг сэтгэл зүйн болон эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулна;	ХНХЯ, ЭМЯ, БСШУСЯ, ХТҮГ	2017-2021 он	
		Энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөх сэтгэл зүйч, хуульчид, багш нарыг мэргэшүүлэх, чадавхжуулна.	ХНХЯ, ЭМЯ, БСШУСЯ, ХТҮГ	2017 он	
3.	“Хүн худалдаалах гэмт хэргийн хэлбэр бүрт тохирсон таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх” Зорилт 3-ын хүрээнд:				
3.1.	“бэлгийн мөлжлөг” төрлөөр: зорилтот бүлгүүд, алслагдсан дүүрэг, сургууль завсардсан хүүхэд, биеэ үнэлэгчдэд чиглэсэн ажлыг явуулна:	Зорилтот бүлгүүдэд чиглэсэн арга хэмжээ, сургалтыг оролцоонд суурилсан болон бусад шинэлэг аргаар зохион байгуулна;	ХЗДХЯ Дэд зөвлөл, Цагдаагийн байгууллага, ТББ-ууд	2017-2021 он	25,0
		Хохирогчдын талаарх мэдээллийг авах оновчтой сувгийг судалж бий болгоно;	ХЗДХЯ Дэд зөвлөл, ТББ-ууд		

		Бэлгийн мөлжлөгт өртөж болзошгүй газруудыг судалж хяналт шалгалтыг явуулна.	Цагдаагийн байгууллага, МХЕГ		
3.2	“хөдөлмөрийн мөлжлөг”-ийн төрлөөр Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хүрээнд хийгдэх хяналтыг сайжруулна:	Хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсэлтэй салбарын аж ахуйн нэгж, гадаад улсаас ажиллах хүч оруулж ирдэг аж ахуйн нэгжүүдэд хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлаар хяналт шалгалт хийнэ;	Цагдаагийн байгууллага МХЕГ	2017-2021 он	10,0
		Аж ахуйн нэгжийн удирдлагуудад хөдөлмөрийн мөлжлөгийн талаар сургалтыг тогтмол явуулна.	ХЗДХЯ Дэд зөвлөл		
3.3	“эд эрхтний наймаа”-ийн төрлөөр хилийн болон эмнэлгийн байгууллагын хяналтыг сайжруулж, холбогдох байгууллагын ажилтнуудыг сургалтад хамруулна:	Эмнэлгийн болон хил, гаалийн хяналтын байгууллагуудын ажилтнуудад эд эрхтэний наймааны гэмт хэргийн талаар мэдлэг олгох сургалт явуулах, гарын авлага материалаар хангана;	МХЕГ, Цагдаагийн байгууллага	2017-2021 он	50,0
		Эрдсэл бүхий газруудад хяналт шалгалт хийнэ.	МХЕГ, Цагдаагийн байгууллага		
		Хүний эд эрхтэн хилээр гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хилийн мэргэжлийн хяналтын болон гаалийн хяналт шалгалт, илрүүлэлтийг сайжруулах техник төхөөрөмжөөр хангана.	ХЗДХЯ ГЕГ МХЕГ	2017-2021 он	
3.4	"хүүхэд үрчлэлт"-ийн төрлөөр гэр бүлийн болон гадаадад зорчих, хил нэвтрэхтэй холбоотой хуулийн хэрэгжилтийг хангаж, гадаад, дотоод үрчлэлтийн хяналтыг сайжруулна:	Гадаад, дотоод үрчлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих явцад хүүхэд худалдаалах гэмт хэрэгт өртсөн нь илэрвэл зохих журмын дагуу холбогдох байгууллагад мэдэгдэж арга хэмжээ авна;	ГИХГ, Цагдаагийн байгууллага	2017-2021 он	-
		Хүүхэд үрчлэгдсэн улсад Монгол улсаас суугаа элчин сайдын яам, консулын газартай хамтран ажиллах, мэдээ, мэдээлэл солилцоно;	ХЗДХЯ, ГХЯ, ГИХГ		
3.5	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой зар сурталчилгаанд хяналт тавина:	Гадаадад ажиллуулах, суралцуулах, аялах болон бусад зар сурталчилгаанд хяналт тавьж, хүн худалдаалах ил буюу далд хэлбэрийг илрүүлж холбогдох арга хэмжээ авна.	ХЗДХЯ, Цагдаагийн байгууллага	2017-2021 он	-

4. "Хүн худалдаалахтай тэмцэх ажлыг хэрэгжүүлэгч байгууллагууд болон гадаад улс, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ" гэсэн зорилт 5-ын хүрээнд:					
4.1	Хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, мэргэжилтнүүдийн ажиллах нөхцөл бололцоог бий болгоно:	"Хүн худалдаалах, бие үнэлэхийг зохион байгуулах" гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий бие даасан нэгжийг шинээр бий болгоно;	ХЗДХЯ ЦЕГ	2017 он	20,0
		Хуулийг хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнуудад мэдлэг олгох, тэднийг чадавхжуулах, үйл ажиллагаа явуулах боловсон хүчнийг нэмэгдүүлэх, цаашид тогтмол явуулах тогтолцоог бүрдүүлнэ;	ХЗДХЯ дэд зөвлөл	2017-2021 он	
		Хүн худалдаалах гэмт хэргийн эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, бусад холбогдох хуулиудыг нийцүүлнэ;	ХЗДХЯ	2017 он	
		Хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улс болон орон нутгийн төсөвт тусгуулна;	ХЗДХЯ дэд зөвлөл	2017-2021 он	
		Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллийн сангийн журам боловсруулна;	ХЗДХЯ дэд зөвлөл	2017 он	
		Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий Цагдаагийн байгууллага /газар, хэлтэс/, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, гадаад хэргийн яамны консулын газар болон холбогдох бусад байгууллагын харилцан шуурхай мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээг бий болгож хариуцсан ажилтан /мэргэжилтэнг/ бэлтгэж сургана;	ХЗДХЯ дэд зөвлөл	2017-2021 он	
		Хууль хяналтын байгууллагын алба хаагчдад Хүн худалдаалах гэмт хэргийн тухай ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх, таслан зогсоход техникийн дэвшлийг хэрхэн ашиглах арга барил, ур чадварыг нэмэгдүүлэх, бусад орны хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаас туршлага судлуулах зорилгоор сургалтанд хамруулна.	ХЗДХЯ дэд зөвлөл	2017-2021 он	
4.2	Хуулийн хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт өгнө:	Хуулийн хэрэгжилтэд мониторинг хийнэ;	ХЗДХЯ	2017-2021 он	



		Мэргэжлийн хяналтын байгууллага, орон нутгийн засаг захиргаа, цагдаагийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор хуулийн хэрэгжилтийн явцын талаар хэлэлцүүлэг хийж зөвлөмж гаргана;	Дэд зөвлөл	2017- 2018 он	-
		Хүн худалдаалахтай тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд улсын хэмжээнд хяналт, шалгалт хийж холбогдох арга хэмжээг авна;	Дэд зөвлөл	2017- 2018 он	
		Хуульд нийцсэн хяналт шалгалт, мониторингийн дүгнэлтэд үндэслэн холбогдох бусад ажлуудыг хийнэ.	Дэд зөвлөл	2017-2021 он	
4.3	НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол улсад хүн худалдаалахтай тэмцэх талаар ирүүлсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ:	Олон улсын гэрээний дагуу хийх ажлуудыг жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.	ХЗДХЯ, ГХЯ	2016-2021 он	
4.4	Монгол иргэд ихээр зорчдог, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болдог улс орнуудтай хамтын ажиллагааг бий болгох өргөжүүлнэ:	МАКАО-тай хийсэн хэлэлцээрийн явцыг дүгнэн цаашид хийх арга хэмжээг төлөвлөнө;	ГХЯ	2017 он	
		Европын холбооны улсуудтай хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагааг бий болгох талаар судалгаа хийнэ;			
		Малайз, Турк, Казакстан зэрэг орон, Хонконгтай хэлэлцээр буюу санамж бичиг байгуулах талаар судална.		2018 он	
Нийт төсөв:					565,0